



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/250.

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,
тендер хүчингүй болгож, шууд гэрээ
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.3, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 30 дугаар зөвлөмжийн дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газарт 2023 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тендерийн 9 дүгээр багц Дотоодод үйлдвэрлэгдсэн тарилгын уусмалыг 53,538,600 (тавин гурван сая таван зуун гучин найман мянга зургаан зуу) төгрөгөөр Энхийн шүүдэр ХХК-иар гүйцэтгүүлсүгэй.

2.Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн 10 дугаар багц Эмнэлгийн хэрэгсэл, 12 дугаар багц Ариутгал, халдваргүйтлийн бодисын багц, оролцогч ороогүй 1 дүгээр багц Сэтгэц нөлөөт, сэтгэл заслын эм бэлдмэлүүд, 2 дугаар багц Халуун бууруулах, өвчин намдаах эм, 3 дугаар багц Зүрх судас, тархины цусан хангамжид нөлөөлөх эм, 5 дугаар багц Хоол боловсруулах эрхтэн тогтолцоонд нөлөөлөх эм, 6 дугаар багц Нөхөн үржихүйн эм бэлдмэлүүд, 7 дугаар багц Амин дэм, 8 дугаар багц Дотоодод үйлдвэрлэгдсэн эм багцуудыг тус тус хүчингүй болгосугай

3.Дээрх шалгарсан багцуудад гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авч, гэрээний хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгох, хүчингүй болсон багцуудад шууд гэрээ байгуулахыг аймгийн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т зөвшөөрсүгэй.

4.Тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдийн бараа нийлүүлэлтийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, гарсан зөрчлийг тухай бүр арилгаж тайланг нэгтгэн танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т даалгасугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 0467

D:My Doc. Zahiramj. Zasag darga